



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/35/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чингис хот</p> <p>2022 он</p>	<p>Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Туяа Утас: 99028942 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Contents

Contents.....	1
1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.2 Албан шаардлага.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
6.1. Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/35 /НА-СТА-ТШЗ
Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/35/НА-СТА-ТШЗ
Албан шаардлага 2021.03.09 №	ХЭА-2022/35/НА-СТА-ТШЗ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐3.᠒᠒ № ᠒᠖᠖

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>510,794,483.09</u>	<u>522,815,039.60</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	8,300.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	8,300.00
3121	Төгрөг	00.00	8,300.00
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	8,300.00
33	АВЛАГА	77,242,305.49	30,267,513.00
335	Бусад авлага	77,242,305.49	30,267,513.00
3351	Байгууллагаас авах авлага	77,242,305.49	30,267,513.00
35	БАРАА МАТЕРИАЛ	433,552,177.60	492,539,226.60
354	Хангамжийн материал	433,552,177.60	492,539,226.60
35410	Бичиг хэргийн материал	2,248,835.00	1,279,900.00
35420	Аж ахуйн материал	379,882,512.60	446,629,796.60
35430	Сэлбэг хэрэгсэл	40,156,530.00	40,569,530.00
35440	Түлш, шатах тослох материал	11,264,300.00	4,060,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,844,869,704.99</u>	<u>3,178,249,631.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,844,869,704.99	3,178,249,631.02
392	Биет хөрөнгө	2,579,771,371.77	2,901,399,631.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,159,909,300.00	2,493,616,783.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-130,549,973.94	-185,546,566.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	345,683,333.24	416,410,773.24
39204	Хуримтлагдсан элэгдэл	-204,139,166.60	-225,372,499.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	675,046,181.39	720,763,867.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	-451,370,852.81	-471,555,075.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	326,428,354.77	329,654,744.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-262,154,665.66	-279,228,724.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	252,996,333.00	252,996,333.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-132,077,471.62	-150,340,003.66
393	Биет бус хөрөнгө	265,098,333.22	276,849,999.98
39301	Програм хангамж	107,924,000.00	110,304,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-98,025,666.78	-106,154,000.02
39303	Бусад биет бус хөрөнгө	255,200,000.00	272,700,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,355,664,188.08</u>	<u>3,701,064,670.62</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>23,893,173.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,893,173.00	00.00
413	Өглөг	23,893,173.00	00.00
4136	Бусад өглөг	23,893,173.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	23,893,173.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,331,771,015.08</u>	<u>3,701,064,670.62</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,331,771,015.08	3,701,064,670.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,485,687,328.00	1,485,687,328.00
51101	Өмч: - төрийн	1,230,487,328.00	1,230,487,328.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	255,200,000.00	255,200,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	721,548,490.93	1,090,842,146.47
51210	Өмнөх үеийн үр дүн	721,548,490.93	721,548,490.93

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	369,293,655.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,124,535,196.15	1,124,535,196.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,355,664,188.08</u>	<u>3,701,064,670.62</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (᠒)	3,304,411,098.00	4,179,706,363.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,780,400.00	680,536,598.82
12᠐	Нийтлэг татварын бус орлого	127,900,400.00	600,792,598.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,900,400.00	600,792,598.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,198,400.00	32,741,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	98,702,000.00	568,050,998.82
122	Тусламжийн орлого	6,880,000.00	79,744,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	6,880,000.00	79,744,000.00
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,169,630,698.00	3,499,169,765.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,114,367,798.00	1,229,738,465.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	57,703,152.00	41,143,829.00
131104	Дээд шагна төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шагна төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215,761,179.00	238,791,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	840,903,467.00	949,802,678.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,055,262,900.00	2,269,431,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,055,262,900.00	2,269,431,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,348,152,308.06	3,747,061,208.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,348,152,308.06	3,747,061,208.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,057,027,181.23	3,643,961,718.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	907,571,230.48	920,799,275.33
210101	Үндсэн цалин	647,582,310.48	489,128,802.51
210102	Нэмэгдэл	00.00	169,649,621.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	35,783,755.36
210105	Гэрээт ажлын хөлс	259,988,920.00	226,237,095.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,918,230.07	113,737,997.58
210201	Тэтгэврийн даатгал	75,749,653.81	78,408,850.47
210202	Тэтгэмжийн даатгал	8,562,432.75	8,201,243.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,966,448.78	6,989,449.63
210204	Ажилгүйдлийн даатгал	2,005,900.97	1,730,660.34
210205	Эрүүд мэндийн даатгал	37,633,793.76	18,407,793.96

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,756,255.86	147,642,466.64
210301	Гэрэл, цахилгаан	19,179,529.94	17,245,098.04
210302	Түлш, халаалт	103,587,366.70	96,692,840.60
210303	Цэвэр, бохир ус	3,789,359.22	2,354,528.00
210304	Байрны түрээс	34,200,000.00	31,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	108,719,262.97	96,912,822.53
210401	Бичиг хэрэг	13,633,500.00	15,626,335.00
210402	Тээвэр, шагахуун	59,136,803.00	49,307,544.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,895,340.96	22,882,887.53
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөлдөөний устгал, армугал	764,800.00	405,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,288,819.01	8,690,556.00
2105	Нормативт зардал	200,000.00	1,032,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	1,032,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,195,839.43	58,666,907.28
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,299,682.76	4,674,150.28
210602	Тавилга	1,066,666.67	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,413,650.00	5,078,300.00
210604	Урсгал засвар	55,415,840.00	48,914,457.00
2107	Томилолт, зочны зардал	31,879,000.00	23,317,500.00
210702	Дотоод албан томилолт	31,879,000.00	23,317,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,555,428.00	24,778,886.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	616,000.00	340,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,412,000.00	2,822,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,697,400.00	6,227,375.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	441,528.00	611,693.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,223,500.00	14,429,300.00
210807	Газрын төлбөр	00.00	194,118.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,633,231,934.42	2,257,073,363.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,391,836,640.00	2,023,754,790.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	241,395,294.42	233,318,572.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	291,125,126.83	103,099,489.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,007,624.00	87,667,437.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,449,400.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,279,500.00	57,847,174.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,278,724.00	29,820,263.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	198,117,502.83	15,432,052.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	198,117,502.83	15,432,052.56

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-43,741,210.06</u>	<u>432,645,155.54</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40,962,500.00	63,351,500.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	40,962,500.00	63,351,500.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-40,962,500.00	-63,351,500.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-84,703,710.06</u>	<u>369,293,655.54</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь өрөлцөөны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	753,012,316.60	3,363,234,840.75
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	753,012,316.60	3,363,234,840.75
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-84,703,710.06	-84,703,710.06
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	721,548,490.93	3,331,771,015.08
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	721,548,490.93	3,331,771,015.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	721,548,490.93	3,331,771,015.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	369,293,655.54	369,293,655.54
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,485,687,328.00	1,124,535,196.15	1,090,842,146.47	3,701,064,670.62

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,198,829,098.00</u>	<u>3,609,153,670.49</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,198,400.00	32,741,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,198,400.00	32,741,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,198,400.00	32,741,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,198,400.00	32,741,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,169,630,698.00	3,576,412,070.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,114,367,798.00	1,306,980,770.49
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	57,703,152.00	59,342,690.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215,761,179.00	239,122,040.49
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	840,903,467.00	1,008,516,040.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,055,262,900.00	2,269,431,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,055,262,900.00	2,269,431,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,198,829,098.00</u>	<u>3,609,145,370.49</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,198,829,098.00	3,609,145,370.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,906,640,471.17	3,475,778,367.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	927,059,708.38	920,296,801.92
210101	Үндсэн цалин	427,249,536.38	488,616,329.10
210102	Нэмэгдэл	170,873,231.00	169,659,621.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,374,044.00	35,783,755.36
210105	Гэрээт ажлын хөлс	290,562,897.00	226,237,095.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,506,946.07	114,240,470.99
210201	Тэтгэврийн даатгал	76,287,351.81	78,408,850.47
210202	Тэтгэмжийн даатгал	8,447,407.75	8,703,716.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,464,641.78	6,989,449.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,982,895.97	1,730,660.34
210205	Эрүүл мэндийн даатгал	17,324,648.76	18,407,793.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,773,010.76	147,883,014.64
210301	Гэрэл, цахилгаан	20,687,861.16	17,245,098.04
210302	Түлш, халаалт	103,466,533.60	96,692,840.60
210303	Цэвэр, бохир ус	2,418,616.00	2,595,076.00
210304	Байрны түрээс	34,200,000.00	31,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	112,262,347.96	87,051,731.53
210401	Бичиг хэрэг	14,192,715.00	13,998,600.00

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	60,054,803.00	42,841,444.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,003,040.96	21,836,787.53
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,079,800.00	405,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,931,989.00	7,969,400.00
2105	Нормативт зардал	800,000.00	966,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	966,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	139,099,334.00	76,521,627.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,181,869.00	27,648,890.00
210602	Тавилга	4,478,900.00	6,101,860.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,993,700.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	76,444,865.00	41,270,877.00
2107	Томилолт, зочны зардал	27,109,000.00	20,862,500.00
210702	Дотоод албан томилолт	27,109,000.00	20,862,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,949,968.00	27,698,286.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	616,000.00	340,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,412,000.00	2,822,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,697,400.00	6,230,875.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	441,528.00	608,193.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,607,040.00	17,348,700.00
210807	Газрын төлбөр	00.00	194,118.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,388,080,156.00	2,080,257,235.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,388,080,156.00	2,080,257,235.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292,188,626.83	133,367,002.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,071,124.00	87,667,437.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,449,400.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,279,500.00	57,847,174.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,342,224.00	29,820,263.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	198,117,502.83	45,699,565.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	198,117,502.83	45,699,565.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	8,300.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	8,300.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,300.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,289,431,300.00	2,277,035,731.25	12,395,568.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,289,431,300.00	2,277,035,731.25	12,395,568.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,211,340,800.00	2,199,568,294.25	11,772,505.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	904,471,200.00	903,897,860.12	573,339.88
210101	Үндсэн цалин	459,082,600.00	488,616,329.10	-29,533,729.10
210102	Нэмэгдэл	182,731,000.00	169,659,621.66	13,071,378.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,093,000.00	35,783,755.36	-690,755.36
210105	Гэрээт ажлын хөлс	227,564,600.00	209,838,154.00	17,726,446.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,711,100.00	112,114,838.96	596,261.04
210201	Тэтгэврийн даатгал	77,352,300.00	76,927,112.22	425,187.78
210202	Тэтгэмжийн даатгал	8,089,700.00	8,542,743.15	-453,043.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,271,800.00	6,860,670.84	411,129.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,817,900.00	1,698,465.69	119,434.31
210205	Эрүүл мэндийн даатгал	18,179,400.00	18,085,847.06	93,552.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,729,600.00	147,883,014.64	846,585.36
210301	Гэрэл, цахилгаан	17,520,000.00	17,245,098.04	274,901.96
210302	Түлш, халаалт	96,809,600.00	96,692,840.60	116,759.40
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,595,076.00	404,924.00
210304	Байрны түрээс	31,400,000.00	31,350,000.00	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	87,155,400.00	87,051,731.53	103,668.47
210401	Бичиг хэрэг	14,029,600.00	13,998,600.00	31,000.00
210402	Тээвэр, шагахуун	42,855,300.00	42,841,444.00	13,856.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,853,700.00	21,836,787.53	16,912.47
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	405,500.00	-45,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,056,800.00	7,969,400.00	87,400.00
2105	Нормативт зардал	966,700.00	966,700.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	966,700.00	966,700.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,565,600.00	75,541,627.00	23,973.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,662,300.00	27,648,890.00	13,410.00
210602	Тавилга	6,110,000.00	6,101,860.00	8,140.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	40,293,300.00	40,290,877.00	2,423.00
2107	Томилолт, зочны зардал	20,991,500.00	20,862,500.00	129,000.00
210702	Дотоод албан томилолт	20,991,500.00	20,862,500.00	129,000.00

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,341,400.00	27,698,286.00	1,643,114.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,740,000.00	340,000.00	1,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,822,400.00	2,822,400.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,233,300.00	6,230,875.00	2,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	614,700.00	608,193.00	6,507.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	157,700.00	154,000.00	3,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,390,000.00	17,348,700.00	41,300.00
210807	Газрын төлбөр	383,300.00	194,118.00	189,182.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	831408300.00	823551736.00	7,856,564.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	831,408,300.00	823,551,736.00	7,856,564.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78090500.00	77467437.00	623,063.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,090,500.00	77,467,437.00	623,063.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,847,200.00	57,847,174.00	26.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,243,300.00	19,620,263.00	623,037.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,289,431,300.00	2,277,035,731.25	12,395,568.75
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,269,431,300.00	2,254,502,431.25	14,928,868.75
132001	Орон нутгийн төсвөөс	2,269,431,300.00	2,254,502,431.25	14,928,868.75
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	22,533,300.00	-2,533,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	22,533,300.00	-2,533,300.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,300.00	-8,300.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	69.00	69.00	0.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	31.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	28.00	28.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,306,980,770.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,306,980,770.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,276,210,073.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,398,941.80
210105	Гэрээт ажлын хөлс	16,398,941.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,125,632.03
210201	Тэтгэврийн даатгал	1,481,738.25
210202	Тэтгэмжийн даатгал	160,973.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	128,778.79
210204	Ажилгүйдлийн даатгал	32,194.65
210205	Эрүүл мэндийн даатгал	321,946.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	980,000.00
210604	Урсгал засвар	980,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,256,705,499.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,256,705,499.85
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,770,696.81
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	30,770,696.81
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,306,980,770.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,306,980,770.49
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	59,342,690.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	239,122,040.49
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,008,516,040.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 9/142 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах,...” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,311.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 33.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 24.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 3,701.0 сая төгрөг болж, өмнөх оноос 345.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0.0	0.0
Авлага	77.2	30.3	(46.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	433.5	492.5	59.0
Үндсэн хөрөнгө	2,844.9	3,178.2	333.3
Нийт хөрөнгө	3,355.6	3,701.0	345.4
Өр төлбөр	23.9	-	(23.9)
Засгийн газрын оруулсан капитал	1,485.7	1,485.7	-
Хуримтлагдсан үр дүн	721.5	1,090.8	369.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,124.5	1,124.5	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,355.6	3,701.0	345.4

Авлага дансны үлдэгдэлд Сангийн яамнаас Соёлын хэлтэст ирүүлсэн дэмжлэг 15.0 сая төгрөгийн, Зах зээл бэлчээрийн удирдлага төслийн арга хэмжээний 15.3 сая төгрөгийн, нийт 30.3 сая төгрөгийн нэмэлт данснаас төвлөрүүлсэн шилжүүлгийн авлага байна. Авлагын үлдэгдэл 46.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд нэмэлт дансанд төвлөрүүлсэн шилжүүлгийн авлагаар буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 492.5 сая төгрөг болж, 59.0 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд бичиг хэргийн материал 1,3 сая төгрөг, буюу 0.2 хувь, аж ахуйн материал 446.6 сая төгрөг буюу 90.7 хувь, сэлбэг хэрэгсэл 40.5 сая төгрөг буюу 26.6 хувь, түлш шатах тослох материал 4.1 сая төгрөг буюу 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,178.2 сая төгрөг болж 333.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 152.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 414.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 93.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 23.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд цэргийн хэлтсийн дүйцүүлэх албаны төлбөрийг орон нутгийн ерөнхий орлогод шилжүүл байгууллагад төлөх өглөгийн 23.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 1,090.8 сая болж 369.3 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 875.3 сая төгрөгөөр буюу 26.5 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 469.3 сая төгрөгөөр, хандив тусламжийн орлого 72.9 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 214.2 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 23.0 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 108.9 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 3,747.0 сая төгрөг болж өмнөх оноос 398.9 сая төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа үйлчилгээний бусад зардал 631.9 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын нөөц хөрөнгөөс ковид 19 цар тахалтай тэмцэх зардал гарсантай холбоотой байна. Тайлант онд байр ашиглалтын зардал 13.1 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 11.3 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 3.5 сая төгрөгөөр, томилолтын зардал 8.6 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэг 188.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,879.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 410.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2,289.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,289.4 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 2,269.4 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 20.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,269.4 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 22.5 сая, нийт 2,291.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,277.0 сая төгрөгийг зарцуулж 14.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 239.1 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,008.5 сая, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 59.3 сая төгрөг, нийт 1,307.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1,276.2 сая төгрөгийг зарцуулж, нийт 30.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, Сангийн яамнаас Соёлын хэлтэст ирүүлсэн дэмжлэг 15.0 сая төгрөгийн, Зах зээл бэлчээрийн удирдлага төслийн арга хэмжээний 15.3 сая төгрөгийн, нийт 30.3 сая төгрөгийн үлдэгдлээр авлага үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийт мэдээлбэл зохих 6639.0 сая төгрөгийн 393 мэдээллээс 5081.9 сая төгрөгийн 361 мэдээллийг мэдээлж, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1442.8 сая төгрөгийн 21, зарлагын 52.3 сая төгрөгийн 11 гүйлгээ, нийт 1557.1 сая төгрөгийн 32 гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснөөс албан шаардлагыг хэрэгжүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлэх, хөрөнгө түрээслүүлэх гэрээг байгуулахдаа заалтуудыг тодорхой тусгаж, биелэлтийг хангаж ажиллах, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгө, бараа материалын дансны бүртгэл, ашиглалтын байдлыг авч үзэхээр шийдвэрлэв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,726.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайланд 145.9 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 1,560.5 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

1. Цалингийн зардлыг санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тулгахад үр дүнгийн тайланд 0.5 сая төгрөгөөр цалингийн зардлыг дутуу, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг илүү тусгасныг залруулсан.
2. Аж ахуйн бараа материалын үлдэгдэл дэх зарцуулсан боловч үлдэгдлээр илэрхийлсэн 17.4 сая төгрөгийн хөрөнгийг зарлагдаулж залруулсан.
3. Аж ахуйн бараа материалын дансанд цэргийн штабын командын байшинг хөрөнгийн ангилал зөрүүлэн бүртгэснийг залруулсан.
4. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 61.6 сая төгрөгийн 2 автомашин, 57.0 сая төгрөгийн жолооч, манаач нарын байр, нийт 118.6 сая төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгээгүйг залруулж бүртгүүлсэн.

4.2 Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй 1,560.5 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Нийт мэдээлбэл зохих 6639.0 сая төгрөгийн 393 мэдээллээс 5081.9 сая төгрөгийн 361 мэдээллийг мэдээлж, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1442.8 сая төгрөгийн 21, зарлагын 52.3 сая төгрөгийн 11 гүйлгээ, нийт 1557.1 сая төгрөгийн 32 гүйлгээг мэдээлээгүй.
2. Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 3.4 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.
3. Өмнөх аудитаар 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснөөс албан шаардлагыг хэрэгжүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлэх, хөрөнгө түрээслүүлэх гэрээг байгуулахдаа заалтуудыг тодорхой тусгаж, биелэлтийг хангаж ажиллах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн хариулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн ЗДТГ-ын төсөвт бараа үйлчилгээний бусад зардалд батлагдсан Засаг даргын нөөц сангийн зарцуулалтад 1-р гарын үсгийг СТСХ-ийн дарга, 2-р гарын үсгийг ЗДТГ-ын нягтлан бодогч зурж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.1."Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна.16.4.15.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргын Тамгын газрын төсвийн;" заалтад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид нийцээгүй дээрх зөрчлийг арилгаж, төсвийн шууд захирагч Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах

2. Хууль тогтоомжийн хэрэгжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Няmodo трейд ХХК-д 20.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь Засаг даргын нөөц сангийн журамд нийцээгүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид нийцээгүй дээрх зөрчлийг дахин давтахгүй, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	8	169.3	4	145.9			2	3.4	2	20.0
Дүн		8	169.3	4	145.9			2	3.4	2	20.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар	1	1,557.1					1	1,557.1		
Дүн		1	1,557.1					1	1,557.1		
Нийт дүн		9	1,726.4	4	145.9			3	1,560.5	2	20.0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 183/А 2370447
ХЭА 2022/35/НА-ТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгснөөс албан шаардлагыг хэрэгжүүлж, шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлэх, хөрөнгө түрээслүүлэх гэрээг байгуулахдаа заалтуудыг тодорхой тусгаж, биелэлтийг хангаж ажиллах, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.3. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэсэн заалтад нийцээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317144237
СЮА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 184/А 2370447.
ХТ-2022/35/НА-СТА-ТШТ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 3.4 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.ТУЯА

Д.ОЮУНТУЯА

2317141297
СЮАӨН45 974982



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 185/А2370447
ХТ-2022/35/НА-СТА-ТШС

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт мэдээлбэл зохих 6639.0 сая төгрөгийн 393 мэдээллээс 5081.9 сая төгрөгийн 361 мэдээллийг мэдээлж, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1442.8 сая төгрөгийн 21, зарлагын 52.3 сая төгрөгийн 11 гүйлгээ, нийт 1557.1 сая төгрөгийн 32 гүйлгээг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулдаггүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатар, нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

02304 08